



МИК ХОЛДИНГ ХК

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

20 22 оны 7 сарын 29 өдөр

№ 22/01

Улаанбаатар хот

### *Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 22/08 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон “Мэжик консалтинг аудит” ХХК-ийн гаргасан 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Ч.ХАШЧУЛУУН





МИК ХОЛДИНГ ХК

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

20... оны ... сарын ... өдөр

№ .../...

Улаанбаатар хот

### Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар-зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:
  - 1.1. 2.2-г “Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол /14210/, Энхтайваны өргөн чөлөө 19, 13-р давхар” гэснийг “Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу /15160/, Д.Сүхбаатарын талбай гудамж, 11 тоот” гэж өөрчлөх;
  - 1.2. 9.4-г “ХЭХ-ын шийдвэрээр ТУЗ-ийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийг ТУЗ-ийн ээлжит бус сонгуулиар сонгоно. Харин бүрэн эрх нь хугацаанаас өмнө дуусгавар болсон гишүүний оронд ажиллах этгээдийг ТУЗ томилно.” гэж нэмэлт, өөрчлөлт оруулах;
  - 1.3. 9.6-г “ТУЗ дараах тохиолдолд ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох асуудлыг шийдвэрлэж болно. Үүнд:
    - 9.6.1. Гурван сар буюу түүнээс дээш хугацаагаар ажиллах боломжгүй болсон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан;
    - 9.6.2. ТУЗ-ийн гишүүнд анх санал болгосон этгээдээс төлөөллөө өөрчлөх талаар тодорхой санал гаргасан;
    - 9.6.3. Эрүүл мэндийн шалтгаанаар ажиллах боломжгүй болсон тухай мэдэгдсэн;
    - 9.6.4. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон;
    - 9.6.5. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр сураггүй алга болсонд тооцогдсон;
    - 9.6.6. Нас барсан, эсхүл шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нас барсанд тооцогдсон;
    - 9.6.7. ТУЗ-ийн гишүүн ёс зүйн ноцтой зөрчил гаргасан;
    - 9.6.8. Удаан хугацаагаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон бусад тохиолдол.” гэж нэмэлт, өөрчлөлт оруулах;
  - 1.4. “Энэ дүрмийн 9.6-д заасан үндэслэлээр ТУЗ-ийн гишүүдийн 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй болсон буюу ажиллахгүй болсон тохиолдолд ТУЗ-ийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадамжгүйд тооцож ХЭХ-ыг хуралдуулна.” гэж 9.6<sup>1</sup> заалтаар нэмж оруулах.
2. Энэ тогтоолын 1-г заасан нэмэлт, өөрчлөлтийн талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлэх болон улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Ч.ХАШЧУЛУУН



МИК ХОЛДИНГ ХК

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 4 сарын 29 өдөр

№ 22/03

Улаанбаатар хот

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.12 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2022 оны 3 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2022 оны 5 дугаар 01-ний өдрөөс 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх цалингийн зардлын төсвийг энэ тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын Хавсралтаар батлагдсан зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Хашчулуун)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Ч.ХАШЧУЛУУН



“МИК Холдинг” ХК-ийн 2022 оны 4 дүгээр сарын 29-ний  
өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын  
22/03 дугаартай тогтоолын Хавсралт



**"МИК ХОЛДИНГ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН  
ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

/Хамрах хугацаа: 2022.05.01-2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл/

Зардлын төрөл	Давтамж	Хүний тоо	Үүнээс:			
			2022/05/01-2022/12/31		2023/01/01-2023/04/30	
			суурь	нэмэгдэл	суурь	нэмэгдэл
Цалин	12	9	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
ТУЗ-ийн гишүүн	12	9	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
НДШ	12	9	6,199,200	4,428,000	3,099,600	2,214,000
Нийт зардал	12	9	56,599,200	40,428,000	28,299,600	20,214,000